

## **“ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ, ТӨЛБӨРИЙН АРГА, ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ” ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

**2025.11.05**

**Улаанбаатар хот**

### **Нэг. Үндэслэл:**

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагын “Нэг иргэнээр тооцсон санхүүжилт”-ийг улсын төсвийн эх үүсвэрээр “Төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт”-ийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр заасан. Эрүүл мэндийн даатгалын сангийн төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт 2024 онд 746.8 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байсан бол 2025 оны батлагдсан төсөвт 219.5 тэрбум төгрөг (29.4 хувь)-өөр нэмэгдүүлж 966.3 тэрбум төгрөг болгон баталсан. Уг төсөв 2025 оны 6 дугаар сард хийгдсэн төсвийн тодотголын нөлөөгөөр 44.7 тэрбум төгрөг (4.6 хувь)-өөр буурч 921.6 тэрбум төгрөг болсон. Шалтгаан нь Засгийн газрын бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон, улсын нэгдсэн төсвийн орлого буурч тэнцэл алдагдсан, төрийн оролцоог багасгаж, зарим үйлчилгээг хувийн хэвшилд шилжүүлэх замаар төрийн албан хаагчийн тоог аажмаар бууруулах стратегийг баримталж нийт төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах шийдвэр гарсантай холбогдуулан эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийг танасан болно.

### **Хоёр. Тогтоолын өөрчлөлт хийх шалтгаан:**

Анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагын “Нэг иргэнээр тооцсон санхүүжилт” 2024 оны төсвийн гүйцэтгэлээр 345.5 тэрбум төгрөг байсан бол 2025 оны баталсан төсөвт 70.5 тэрбум төгрөг (20.4 хувь)-өөр нэмэгдүүлж 416.0 тэрбум төгрөг болгон баталсан. Уг нэмэгдсэн төсвийн 66.3 тэрбум төгрөг буюу 94.1 хувь нь сум, тосгоны эрүүл мэндийн төвийн санхүүжилт, 4.1 тэрбум төгрөг буюу 5.9 хувь нь өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүжилтийг нэмэгдүүлэхэд төсөвлөгдсөн. Төсвийн тодотголын дараа батлагдсан уг төсөв 404.1 тэрбум төгрөг болж 11.9 тэрбум төгрөг (2.9 хувь)-өөр буурсан.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр сум, тосгоны эрүүл мэндийн төвийн “Нэг иргэнээр тооцсон санхүүжилт” 137.2 тэрбум төгрөг буюу өнгөрсөн оны эхний хагас жилтэй харьцуулахад 30.2 тэрбум төгрөг (28.2 хувь)-өөр, өрхийн эрүүл мэндийн төвийн “Нэг иргэнээр тооцсон санхүүжилт” 63.8 тэрбум төгрөг буюу өнгөрсөн оны эхний хагас жилтэй харьцуулахад 1.6 тэрбум төгрөг (2.6 хувь)-өөр тус тус нэмэгдсэн байна.

Төсвийн тодотголын нөлөөгөөр эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв буурсантай холбогдуулан сум, тосгоны эрүүл мэндийн төвд олгох “Нэг иргэнээр тооцсон санхүүжилт”-ийг бууруулах зайлшгүй шаардлагатай болсон. Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн 2025 оны 8 дугаар сарын байдлаар харилцах дансны үлдэгдэл болон төсвийн зарлагын гүйцэтгэлийг харахад санхүүгийн хүндрэл үүссэн байгууллагын тоо маш цөөн байна.

Төсвийн бууралтад зөвхөн сум, тосгоны эрүүл мэндийн төвд олгох “Нэг иргэнээр тооцсон санхүүжилт”-ийг хамааруулж байгаа бөгөөд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.9 дэх хэсэгт заасан 4 төрлийн тусламж, үйлчилгээ болон сум, тосгоны эмнэлгийн үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээ хамаарахгүй.

#### **Гурав. Тогтоолд орсон гол өөрчлөлт:**

Төсвийн тодотголын дагуу төрийн албан хаагчдын тоог бууруулах шалтгаанаар Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн төсвийг тооцох, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх журам”-ын хавсралт болох “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн газарзүйн коэффициент , орон нутгийн цалингийн нэмэгдлийн индекс”-ийн “Орон нутгийн цалингийн нэмэгдлийн индекс (ОНН)”-ийг шинэчлэн тохируулсан. Бууруулахдаа зөвхөн 2025 оны 4 дүгээр улирлаас эхлэн бууруулахаар тооцсон.

Тогтоолын төслийн нөлөөгөөр өрхийн эрүүл мэндийн төвийн “Нэг иргэнээр тооцсон санхүүжилт” огт өөрчлөгдөхгүй бөгөөд зөвхөн сум, тосгоны эрүүл мэндийн төвийн санхүүжилт буурна. Санхүүжилт буурснаар санхүүгийн хүндрэлд орох эрүүл мэндийн байгууллага байхгүй болно.

### **ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР**